



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2016 оны 12 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 136

Улаанбаатар  
хот

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

1. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах Зөвлөлийг бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай:

- |         |  |
|---------|--|
| Дарга   | -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга                               |
| Гишүүд: | -Сангийн сайд;   |
|         | -Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;                              |
|         | -Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;                              |
|         | -Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;                                 |
|         | -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;                            |
|         | -Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;   |
|         | -Үндэсний хөгжлийн газрын дарга;   |
|         | -Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал; |
|         | -Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал;                        |
|         | -Ерөнхий сайдын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны асуудал хариуцсан зөвлөх;             |
|         | -Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал;  |
|         | -Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч (тохиролцсоноор);          |
|         | -Төрийн бус байгууллагын төлөөлөл;   |


-Төрийн бус байгууллагын төлөөлөл;

-Төрийн бус байгууллагын төлөөлөл.

Нарийн бичгийн дарга -Засгийн газрын ахлах референт.

2. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн ажиллах журмыг баталж мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатад даалгасугай.

3. Зөвлөлийн бүрэлдэхүүнд орох төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг хууль, санхүү, эдийн засгийн салбарын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ажлын туршлага, ашиг сонирхлын зөрчил үүсч болох нөхцөл байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр сонгож, нэг жилийн хугацаатай томилж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатад даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ